



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 1/205

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймгийн Гурвансайхан сумд үйл ажиллагаа явуулдаг "Үнэн бэх" ХХК-ний гантиг чулууны уурхайд ажиллах хүч нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-аас нэвтрүүлж буй иргэдийн тусгаарлах байранд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Дугар (Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Ахлах дэслэгч)

Гишүүд: М.Дамдин (Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 25 дугаар ангийн Аврагч, гал сөнөөгч, Ахлагч)

М.Ёндон (Цагдаагийн газрын Гурвансайхан сумын хэсгийн цагдаа, Дэд ахлагч)

Д.Дашням (Гурвансайхан сумын Эрүүл мэндийн төвийн багийн эмч)

Хоёр. Тусгаарлан ажиглах байрны халдвар хамгааллын дэглэмийг холбогдох дүрэм, журмын дагуу хангуулж, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээг тухай бүр нь аймгийн Онцгой комисст танилцуулахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010578